



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 11 сарын 24 өдөр

Дугаар 01/198

Жавхлант

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, "Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3 дахь заалт, Сумын ИТХ-ын 3 дугаар хуралдааны 2024 оны 19 дүгээр тогтоолын 7 дугаар хавсралтыг тус тус үндэслэн " ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 6 дахь зүйлд заасан "Архидалтгүй Баян-Овоочууд" дэд хөтөлбөрийн хүрээнд сумын архины хамааралтай гэр бүл, иргэдэд "Амьдралд ойрхон харилцаа" сургалтыг зохион байгуулах зардалд 1.000.000 (нэг сая) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх зардлыг "Архидалтгүй Баян-Овоочууд" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас хууль, журмын дагуу холбогдох баримт бичгийг бүрдүүлж, зарцуулахыг Нягтлан бодогч (Э. Уранбайгаль)-д даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (М.Шаравгаваа) -д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ЦОЛМОНБАЯР